



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/13

Эрдэнэт

Хугацаа сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

Үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлт ирүүлсэн “Эрдэнэт дэлхийн гэрэл” сүм, “Эрдэнэт бурхны сүм”, “Алдарт Христийн Эрдэнэт” чуулган, “Монголын илгээлтийн төв”, “Каусар Эрдэнэт мешит” сүмүүдийн хугацааг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс, “Есүсийн чуулган” сүмийн хугацааг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тус тус нэг жилийн хугацаатай сунгасугай.

ДАРГА  Д. МӨНХБАТ